



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/90

Баруун-Урт сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг цуцлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 зүйлийн 11.1.4 дэх заалт, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хилийн бүс нутагт Коронавирусын халдвар (Ковид-19)-ын тархалт нэмэгдэх, экспорт, импортын үйл ажиллагаа тасалдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Эрдэнэцагаан сум дахь “Бичигт” боомтод тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгаж, бусад сумдын нутагт тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг 2022 оны 02 дугаар сарын 15 -ны” өдрөөс эхлэн цуцалсугай.

2. “Бичигт” Боомтод тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасантай холбогдуулан Коронавирусын халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах, тэмцэх, хариу арга хэмжээ авах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Бичигт хөгжил” ОНӨААТҮГ (Н.Ариунтунгалаг), Цагдаагийн тасаг (Б.Мөнхтөр), “Бичигт” хилийн боомтын Гаалийн газар (Н.Амарбаатар), Бичигт боомтын зөвлөл (хурандаа О.Азхүү), Онцгой байдлын газрын 47 дугаар анги (ахлах дэслэгч М.Дамба), Эрдэнэцагаан сумын Засаг дарга (Г.Эрдэнэчулуун)-д тус тус үүрэг болгосугай.

3. Эрдэнэцагаан сумын “Бичигт” боомтоос бусад сумдын нутаг дэвсгэрт тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг цуцалсантай холбогдуулан Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг хариу арга хэмжээ, тандалт, эмнэлгийн тусламж үйлчилгээнд доголдол үүсэх, хариуцлага, хяналт сулрах зэрэг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


4. Бүх шатны боловсролын байгууллага танхимаар хичээллэх болсонтой холбогдуулан сургууль, цэцэрлэгийн орчинд халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд эцэг эх, асран хамгаалагч, багш, сургууль, цэцэрлэгийн захиргаа болон холбогдох бусад байгууллага, албан

тушаалтнуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Л.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай штабын дарга, Засаг даргын орлогч (Д.Шижирбаатар)-д даалгасугай.

6. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн байдлын байдлын зэрэг шилжүүлсэн хугацааг сунгах тухай А/02 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ